



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 1/30

Баян-Овоо

**Цэрэг татлага зохион байгуулах  
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 12, 13 дугаар зүйл, Засгийн газрын 2023 оны мн/124 дүгээр тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2024 оны н/204 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/468 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэрэг татлага зохион байгуулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|        |              |                                                                |
|--------|--------------|----------------------------------------------------------------|
| Дарга  | Д.Гэрэлмаа   | (Засаг даргын Тамгын газрын дарга)                             |
| Гишүүд | М.Мөнхчимэг  | (Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
|        | Ш.Гангантуул | (Соёлын төвийн дарга)                                          |
|        | А.Азжаргал   | (Онон багийн Засаг дарга)                                      |
|        | А.Анар       | (Балж багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)        |
|        | Э.Баасанхүү  | (Баян-Овоо багийн Засаг дарга)                                 |
|        | Г.Ган-Эрдэнэ | (Агац багийн Засаг дарга)                                      |
|        | Г.Билгүүн    | (Хэсгийн төлөөлөгч)                                            |
|        | Э.Мөнхмаа    | (Нийгмийн даатгалын байцаагч)                                  |

2.Зарлан дуудах хуудсыг нэрсийн жагсаалтад орсон цэргийн албанд татагдагч бүрт хүргүүлэн, заасан хугацаанд Цэрэг татлагын байранд бэлэн байлгахыг багийн Засаг дарга нарт, сумын эрүүл мэндийн төвд цусны бүлэг тогтоох, В, С вирус, ДОХ, тэмбүү өвчнийг илрүүлэх шинжилгээг урьдчилан хийсэн байх, цэрэг татлага явагдах өрөө тасалгааг стандартын дагуу ариутгах, хүн нэг бүрийн нэг удаагийн улавч, хувцасны уут, гар ариутгалын бодис бэлтгэж, цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнд ажиллах эмч, мэргэжилтэн, шаардлагатай тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Мөнхчимэг), цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнийг ажиллах нөхцөл, хоол хүнсээр хангах, цэргийн албанд татагдагчдыг үдэж мордуулах, цэргийн албанаас халагдан ирж буй дайчдыг угтан авах, тэднийг ажлын байранд зуучлахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа), сахилга, зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулахыг хэсгийн төлөөлөгч (Г.Билгүүн), зарлан дуудах хуудас хүлээн авсан залуучуудыг 100 хувь эрүүл мэндийн даатгалд

010000340

хамруулахыг Нийгмийн даатгалын байцаагч (Э.Мөнхмаа), цэрэг татлагын байрыг сумын Соёлын төвд зааврын дагуу бэлтгэж, Цэрэг татлагын товчоо, зохион байгуулах бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийг Соёлын төвийн дарга (Ш.Гангантуул) нарт тус тус үүрэг болгосугай.

3.2024 оны 2 дугаар ээлжээр цэргийн албанд татагдагчдыг аймгийн цэрэг татлагын байранд хүлээлгэн өгөх, цэргийн албанаас халагдагсадыг бичиг баримттай нь хүлээн авч суманд авчрах ажлыг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХ-ОД